

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/226-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a></p> <p>Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040      Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036      Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Одсүрэн Утас: 7036-2442      Цахим хаяг: odsurent@audit.gov.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Зөвлөмж .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

## Товчилсон үгийн жагсаалт

---

<b>АДБОУС</b>	<b>Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт</b>
<b>ЗТХС</b>	Зам тээврийн хөгжлийн сайд
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ТӨБЗГ</b>	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>ЦУОШГ</b>	Цаг уур, орчны шинжилгээний газар



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

Ноол. 02.24 № СЭА-2022/226-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС ЦАГ УУР,  
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ С. ЭНХСЭЛЭНГЭ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>90,588,670.83</b>	<b>87,490,826.10</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>90,588,670.83</b>	<b>87,490,826.10</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>53,270,516.04</b>	<b>52,903,173.52</b>
35110	Тусгай зориулалттай материал	53,270,516.04	52,903,173.52
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>37,318,154.79</b>	<b>34,587,652.58</b>
35410	Бичиг хэргийн материал	1,391,600.00	1,306,100.00
35420	Аж ахуйн материал	13,115,354.79	7,383,922.58
35430	Сэлбэг хэрэгсэл	18,837,650.00	18,789,080.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,085,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,973,550.00	4,023,550.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>636,504,194.79</b>	<b>827,614,674.95</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>636,504,194.79</b>	<b>827,614,674.95</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>375,996,194.79</b>	<b>566,831,674.95</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	318,290,983.09	343,282,534.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32,537,554.73)	(46,662,807.41)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	595,201,693.78	104,767,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(546,749,060.80)	(18,588,703.09)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	387,221,337.09	221,419,328.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(347,624,476.99)	(44,849,198.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,480,691.45	15,281,560.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,287,418.10)	(7,818,611.70)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>260,508,000.00</b>	<b>260,783,000.00</b>
39301	Программ хангамж	-	275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	260,508,000.00	260,508,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>727,092,865.62</b>	<b>915,105,501.05</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>727,092,865.62</b>	<b>915,105,501.05</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>727,092,865.62</b>	<b>915,105,501.05</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,295,182,634.93	1,295,182,634.93
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(703,240,405.27)</b>	<b>(504,917,482.55)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(757,380,577.52)	(692,930,117.98)
51220	Тайлант үеийн үр дүн	54,140,172.25	188,012,635.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,150,635.96	124,840,348.67
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>727,092,865.62</b>	<b>915,105,501.05</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,507,255,379.87</b>	<b>1,459,943,852.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>179,304,894.87</b>	<b>274,482,836.85</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>179,304,894.87</b>	<b>274,482,836.85</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,611,700.00</b>	<b>1,130,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,611,700.00	1,130,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	64,017,412.67	207,783,100.00

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	113,675,782.20	65,569,736.85
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,327,950,485.00</b>	<b>1,185,461,016.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,290,480,400.00</b>	<b>1,122,011,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,290,480,400.00	1,122,011,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>37,470,085.00</b>	<b>63,449,616.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,944,485.00	26,710,616.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,525,600.00	6,739,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,453,115,207.62</b>	<b>1,271,931,217.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,453,115,207.62</b>	<b>1,271,931,217.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,285,419,065.62</b>	<b>1,268,176,602.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>936,293,345.00</b>	<b>936,632,886.50</b>
210101	Үндсэн цалин	671,188,640.00	688,565,657.00
210102	Нэмэгдэл	237,663,205.00	220,662,379.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,441,500.00	27,404,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>118,383,334.00</b>	<b>122,865,049.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	81,989,882.00	87,878,262.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,227,500.00	9,227,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,382,000.00	7,380,433.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,798,541.00	1,655,406.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,985,411.00	16,723,448.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>54,957,093.00</b>	<b>53,107,763.24</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,075,493.00	10,275,233.24
210302	Түлш, халаалт	42,378,500.00	40,149,979.00
210303	Цэвэр, бохир ус	2,503,100.00	2,682,551.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,604,935.21</b>	<b>24,061,858.08</b>
210401	Бичиг хэрэг	1,635,000.00	1,246,450.00
210402	Тээвэр, шатахуун	16,797,204.00	14,118,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,157,300.00	3,164,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	41,200.00	7,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,482,903.20	3,761,823.85
210408	Бараа материал акталсны зардал	16,491,328.01	1,763,354.23
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>333,300.00</b>	<b>1,107,390.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	761,090.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	333,300.00	346,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>74,016,192.10</b>	<b>70,137,736.50</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	69,383,692.10	63,970,236.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	132,500.00	385,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	5,782,500.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>6,705,935.00</b>	<b>4,649,465.00</b>
210702	Дотоод албан томиллолт	6,705,935.00	4,649,465.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,221,032.00</b>	<b>11,941,883.44</b>

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,096,900.00	10,529,543.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	781,400.00	334,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	262,300.00	236,125.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,525.00	245,515.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	431,143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	201,200.00	198,000.00
210807	Газрын төлбөр	287,707.00	255,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>41,903,899.31</b>	<b>43,672,570.84</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,903,899.31	43,672,570.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>167,696,142.00</b>	<b>3,754,614.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>159,272,918.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	159,272,918.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,423,224.00</b>	<b>3,754,614.82</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		47,748
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	8,423,224.00	3,706,866.82
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>54,140,172.25</b>	<b>188,012,635.43</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>54,140,172.25</b>	<b>188,012,635.43</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,295,182,634.93</b>	<b>152,306,980.96</b>	<b>(774,536,922.52)</b>	<b>672,952,693.37</b>
<b>2</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	17,156,345.00	17,156,345.00
<b>3</b>	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,295,182,634.93	152,306,980.96	(757,380,577.52)	690,109,038.37
<b>4</b>	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(17,156,345.00)	-	(17,156,345.00)
<b>9</b>	Тайлант үеийн үр дүн	-	-	54,140,172.25	54,140,172.25
<b>10</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,295,182,634.93</b>	<b>135,150,635.96</b>	<b>(703,240,405.27)</b>	<b>727,092,865.62</b>
<b>11</b>	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,295,182,634.93</b>	<b>135,150,635.96</b>	<b>(703,240,405.27)</b>	<b>727,092,865.62</b>
<b>12</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	10,310,287.29	10,310,287.29
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,295,182,634.93</b>	<b>135,150,635.96</b>	<b>(692,930,117.98)</b>	<b>737,403,152.91</b>

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(10,310,287.29)	-	(10,310,287.29)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	188,012,635.43	188,012,635.43
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	(504,917,482.55)	915,105,501.05

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,332,687,147.00</b>	<b>1,186,591,016.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,611,700.00</b>	<b>1,130,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,611,700.00</b>	<b>1,130,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,611,700.00</b>	<b>1,130,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,611,700.00	1,130,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,331,075,447.00</b>	<b>1,185,461,016.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,290,480,400.00</b>	<b>1,122,011,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,290,480,400.00	1,122,011,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>37,470,085.00</b>	<b>63,449,616.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,944,485.00	26,710,616.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,525,600.00	6,739,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>3,124,962.00</b>	<b>0.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,124,962.00	0.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,329,699,147.00</b>	<b>1,159,591,065.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,329,699,147.00</b>	<b>1,159,591,065.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,158,878,043.00</b>	<b>1,155,836,450.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>936,293,345.00</b>	<b>936,632,886.50</b>
210101	Үндсэн цалин	671,188,645.00	671,038,934.00
210102	Нэмэгдэл	237,663,200.00	238,189,102.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,441,500.00	27,404,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>118,383,334.00</b>	<b>122,865,049.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	81,989,882.00	87,878,262.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,227,500.00	9,227,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,382,000.00	7,380,433.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,798,541.00	1,655,406.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,985,411.00	16,723,448.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>56,813,593.00</b>	<b>51,680,263.24</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,075,493.00	10,275,233.24
210302	Түлш, халаалт	44,235,000.00	38,722,479.00
210303	Цэвэр, бохир ус	2,503,100.00	2,682,551.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,849,504.00</b>	<b>20,742,113.00</b>
210401	Бичиг хэрэг	1,748,300.00	1,160,950.00

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210402	Тээвэр, шатахуун	16,797,204.00	14,118,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,385,300.00	3,164,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	41,200.00	7,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,877,500.00	2,290,933.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>383,300.00</b>	<b>1,107,290.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	761,090.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	383,300.00	346,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,456,000.00</b>	<b>6,217,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	520,400.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	435,600.00	435,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	5,782,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,705,935.00</b>	<b>4,649,465.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,705,935.00	4,649,465.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,993,032.00</b>	<b>11,941,883.44</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,868,900.00	10,529,543.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	781,400.00	334,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	262,300.00	236,125.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,525.00	245,515.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	201,200.00	198,000.00
210807	Газрын төлбөр	287,707.00	255,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>170,821,104.00</b>	<b>3,754,614.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>162,397,880.00</b>	<b>0.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,124,962.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	159,272,918.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,423,224.00</b>	<b>3,754,614.82</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		47,748
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	8,423,224.00	3,706,866.82
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,988,000.00</b>	<b>26,999,951.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,988,000.00</b>	<b>26,999,951.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,988,000.00</b>	<b>26,999,951.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,988,000.00</b>	<b>26,999,951.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,988,000.00	26,999,951.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>2,988,000.00</b>	<b>-26,999,951.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт/ хэмнэлт	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,123,011,400.00	1,119,434,533.18	3,576,866.82	99.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,123,011,400.00	1,119,434,533.18	3,576,866.82	99.68

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,123,011,400.00</b>	<b>1,119,434,533.18</b>	<b>3,576,866.82</b>	<b>99.68</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>922,749,800.00</b>	<b>922,675,685.50</b>	<b>74,114.50</b>	<b>99.99</b>
210101	Үндсэн цалин	657,113,800.00	657,081,733.00	32,067.00	100.00
210102	Нэмэгдэл	238,193,200.00	238,189,102.50	4,097.50	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,442,800.00	27,404,850.00	37,950.00	99.86
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>124,571,200.00</b>	<b>121,069,831.00</b>	<b>3,501,369.00</b>	<b>97.19</b>
210201	Тэтгэврийн даатгал	87,661,200.00	86,083,044.00	1,578,156.00	98.20
210202	Тэтгэмжийн даатгал	9,227,500.00	9,227,500.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,382,000.00	7,380,433.00	1,567.00	99.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,845,500.00	1,655,406.00	190,094.00	89.70
210205	Эрүүл мэндийн даатгал	18,455,000.00	16,723,448.00	1,731,552.00	90.62
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,269,100.00</b>	<b>49,268,133.24</b>	<b>966.76</b>	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,276,200.00	10,275,233.24	966.76	99.99
210302	Түлш, халаалт	36,688,000.00	36,688,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,304,900.00	2,304,900.00	-	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,654,300.00</b>	<b>8,654,300.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210401	Бичиг хэрэг	972,200.00	972,200.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	5,059,500.00	5,059,500.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,564,000.00	1,564,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,800.00	7,800.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,050,800.00	1,050,800.00	-	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>346,200.00</b>	<b>346,200.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	346,200.00	346,200.00	-	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,443,400.00</b>	<b>3,443,400.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,008,400.00	2,008,400.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	435,000.00	435,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,448,800.00</b>	<b>3,448,800.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,448,800.00	3,448,800.00	-	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,528,600.00</b>	<b>10,528,183.44</b>	<b>416.56</b>	<b>100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	9,116,100.00	9,115,843.44	256.56	100.00

**Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	334,600.00	334,600.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	236,200.00	236,125.00	75.00	99.97
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,600.00	245,515.00	85.00	99.97
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	143,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	198,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	255,100.00	255,100.00	-	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,123,011,400.00</b>	<b>1,119,386,785.18</b>	<b>3,576,866.82</b>	<b>99.67</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,122,011,400.00</b>	<b>1,118,256,785.18</b>	<b>3,706,866.82</b>	<b>99.66</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,122,011,400.00	1,118,256,785.18	3,706,866.82	99.66
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,130,000.00</b>	<b>(130,000.00)</b>	<b>113.00</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,130,000.00	(130,000.00)	113.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>80.00</b>	<b>77.00</b>	<b>3.00</b>	<b>96.25</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	76.00	73.00	3.00	96.05
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>80.00</b>	<b>77.00</b>	<b>3.00</b>	<b>96.25</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	80.00	77.00	3.00	96.25

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт/хэмнэлт	Хувь
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>63,449,616.00</b>	<b>63,449,616.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>38,458,065.00</b>	<b>38,458,065.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>38,410,317.00</b>	<b>38,410,317.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>13,957,201.00</b>	<b>13,957,201.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210101	Үндсэн цалин	13,957,201.00	13,957,201.00	0.00	100
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,795,218.00</b>	<b>1,795,218.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,795,218.00	1,795,218.00	0.00	100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,412,130.00</b>	<b>2,412,130.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210302	Түлш, халаалт	2,034,479.00	2,034,479.00	0.00	100
210303	Цэвэр, бохир ус	377,651.00	377,651.00	0.00	100

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,087,813.00</b>	<b>12,087,813.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210401	Бичиг хэрэг	188,750.00	188,750.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	9,058,930.00	9,058,930.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00	1,600,000.00	0.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,240,133.00	1,240,133.00	0.00	100
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>761,090.00</b>	<b>761,090.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	761,090.00	761,090.00	0.00	100
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,782,500.00</b>	<b>4,782,500.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210604	Урсгал засвар	4,782,500.00	4,782,500.00	0.00	100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,200,665.00</b>	<b>1,200,665.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210702	Дотоод албан томилолт	1,200,665.00	1,200,665.00	0.00	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,413,700.00</b>	<b>1,413,700.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,413,700.00	1,413,700.00	0.00	100
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,748.00</b>	<b>47,748.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
213305	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,748.00	47,748.00	0.00	100
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>24,991,551.00</b>	<b>24,991,551.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	24,991,551.00	24,991,551.00	0.00	100
221001	Их засвар	24,991,551.00	24,991,551.00	0.00	100
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>63,401,868.00</b>	<b>63,401,868.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>63,449,616.00</b>	<b>63,449,616.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00	0.00	100
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,710,616.00	26,710,616.00	0.00	100
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,739,000.00	6,739,000.00	0.00	100

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв /цаашид Ус цаг уур, орчны шинжилгээний төв гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх, төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдлийг олгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 07/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ус цаг уур орчны шинжилгээний төв нь “Үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах, байгаль цаг агаарын болзошгүй аюул, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргэмжлүүлэх, цаг агаар уур амьсгалын нөөцийг бүрэн дүүрэн ашиглуулах нөхцлийг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны зорилт, чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ус цаг уур орчны төлөв байдлын урьдчилсан болон горимын үнэн зөв мэдээ, мэдээллээр төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд шуурхай үйлчлэх
- Нутаг дэвсгэртээ нислэг үйлдэж буй агаарын хөлгийн нислэгт цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээгээр үйлчилж нислэгийн аюулгүй байдлыг хангах
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний өртөө харуулуудыг арга зүйн удирдлагаар хангаж, тэдгээрийн тасралтгүй ажиллах нөхцөлийг

*бүрдүүлэх, холбоо, мэдээлэл сүлжээний найдвартай ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах*

- *Шинжилгээний зориулалттай хэмжих хэрэгслийн хангалт, техник технологийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх, багаж төхөөрөмж материалын нэгдсэн судалгаа гаргах, ашиглалтад хяналт тавих*
- *Шинжилгээ мэдээлэл үйлчилгээний ажлын чиглэлээр гарч буй дүрэм заавар, стандартыг мөрдөж хэрэгжүүлэх*
- *Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах*
- *Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах, ажилд нь сургаж дадлагажуулах мэргэжлийг дээшлүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 1 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- 2 Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- 3 Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- 4 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- 5 УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1,0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудит хийгдээгүй бөгөөд тус төвийн бүтэц зохион байгуулалтад дотоод аудитын нэгж хариуцсан ажилтан байхгүй боловч 2021 оны төлөвлөгөөний дагуу 5-н ажил зохион байгуулж, заавар зөвлөмж хүргүүлэн, хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны урсгал санхүүжилтийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны урсгал санхүүжилтийн орлого болох 1,122,011.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,220.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,854.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 188,012.6 мянган төгрөгөөр буюу 25.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	90,588.7	87,490.8	(3,097.8)
Үндсэн хөрөнгө	636,504.2	827,614.7	191,110.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>727,092.9</b>	<b>915,105.5</b>	<b>188,012.6</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	727,092.9	915,105.5	188,012.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>727,092.9</b>	<b>915,105.5</b>	<b>188,012.6</b>

Бараа материалын дансны үлдэгдэл тайлант онд 87,490.8 мянган төгрөг болж 3,097.8 мянган төгрөгөөр буурсан нь ЦУОШГ-аас 65,569.7 мянган төгрөгийн цаг уурын багаж, техник хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсан болон төсвийн хөрөнгөөр 31,503.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 98,407.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан 1,763.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 945,534.0 мянган төгрөг болж 636,168.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 26,999.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болон дээд шатны төсвийн захирагчаас 14,580.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж буй хөрөнгүүдийг 193,202.7 мянган төгрөгөөр дахин үнэлсэн, ТӨБЗГ-ын шийдвэрээр 20,793.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж, 850,158.0 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэхээр хөрөнгийн бүртгэлээс хассан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 915,105.5 мянган төгрөг болж 188,012.6 мянган төгрөгөөр буурахад хөрөнгийн элэгдлийн зардал голлон нөлөөлсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,288,685.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөгийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гэвч төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн урсгал зардлыг өмнөх оныг гүйцэтгэлээс хэт өндрөөр төсөвлөсөн шалтгаанаар 166,674.3 мянган төгрөгөөр бууруулан төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж төсвийн санхүүжилтийг 1,122,011.4 мянган төгрөгөөр, өөрийн орлогын төлөвлөгөөг 1,000.0 мянган төгрөгөөр тогтоож, нийт **1,123,011.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,122,011.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,130.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн нийт 1,123,141.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **1,119,434.5** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн санхүүжилтээс 3,576.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 130.0 мянган төгрөг зэрэг нийт 3,706.9 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,119,434.5 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 74.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 3,501.4 мянган төгрөгөөр, бусад зардлыг 1.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЦУОШГ-аас 26,710.6 мянган төгрөг, Сангийн сайдын 2021 оны 217 дугаар тушаалаар үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгосон 6,739.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас, нэмэгдүүлэх ажлын 30,000.0 мянган төгрөг зэрэг нийт 63,449.6 мянган төгрөг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 ЦУОШГ-ын 2021 оны А/96 дүгээр тушаалаар 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитаар “Зөрчилгүй” дүгнэгдсэн гэх үндэслэлээр тус төвийн дарга, нягтлан бодогч, нярав нарт нийт 2,117.4 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан буюу тогтоосон хэмжээг хэтрүүлэн олгох шийдвэр гаргаж, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” гэж заасантай нийцэхгүй байна.


Иймд тухайн албан тушаалтнууд холбогдох хууль эрхийн актын дагуу улирал бүр ажлын үр дүнгээ үнэлүүлж, мөнгөн урамшуулал авч байхад санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан, санхүүгийн үйл ажиллагаа сайн гэх үндэслэлээр буюу ажлын үр дүнгийн зөвхөн 1 үзүүлэлтийг үндэслэн урамшууллыг давхардуулан олгох шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс гаргахгүй байх нь зүйтэй юм.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.



#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн мэдээлбэл зохих 147 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны үйл ажиллагаанд 1,123,011.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,119,434.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.3 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хэмнэлтэй үр ашигтай зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлэх.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн мөнгөн кассын тайланг загвар маягт, аргачлалын дагуу гаргаагүй 1,057.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл аваагүй гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 1,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн нийт 114,678.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад тус байгууллагын ажилчдын хувийн 4,248.8 мянган төгрөгийн худалдан авалт орж шивэгдсэн бол харилцагч байгууллагын шивээгүй 77,680.4 мянган төгрөгийн ажил гүйлгээ байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын

цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22,740.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгөгдлөө.

##### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1. Илрүүлэлт: Тайлант онд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийн дагуу нэр төрлөөр бус бөөн дүнгээр 12,182.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ цахим системд шивэгдсэн байна.

1.1.2. Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

1.2.1 Илрүүлэлт: Өмч хамгаалах зөвлөлөөр засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэхийг хэлэлцэж шийдвэрлээгүй, техникийн хувийн хэргийн баяжилтыг хийлгүйгээр автомашины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд 3,850.6 мянган төгрөг, цаг уурын станцуудын галлагаанд 6,707.5 мянган төгрөгийн түлээ, нүүрс зэрэг нийт 10,558.1 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Автомашины сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм” батлах тухай стандарт зааврыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”

батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид автомашины эвдрэл гэмтлийг тогтоосны үндсэн дээр шаардлагатай засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийг шийдвэрлэж байх, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

## 2. Нэмэгдэл цалинтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар бус хагас бүтэн жилээр дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын... албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ... тооцож, сар бүр олгоно", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ын 5-д "Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна" гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирал бүр дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдлийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	3	22,740.6	-	-	-	-	-	-	3	22,740.6
	<b>Нийт</b>	<b>3</b>	<b>22,740.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>22,740.6</b>